



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	7
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Зардлын хэмжээг зохицуулахтай холбоотой эрх зүйн асуудал.....	10
3.2	Авлагатай холбоотой асуудал.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
5	Хавсралт	18
5.1	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18
5.2	Албан шаардлага	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 844
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч, Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн авлагыг барагдуулах, олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээхэд гарах зардлын хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн нарийвчлан тогтоох санал боловсруулж, шийдвэрлүүлэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, YAГ-ын Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа гүйцэтгэв.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн ХЭГ/880 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.



Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Ерөнхий сайд 2018 оны Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант онд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цацрагийн хэмжилт, шинжилгээ явуулах, дозиметрийн тохируулга, баталгаажуулалт хийх зэрэг 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 186,283.2 сая төгрөгийг зарцуулсан ба хэрэгжилт 91.6 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь холбогдох хууль эрхзүйн болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд холбогдох хууль эрхзүйн болон бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Харин үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



ЗГХЭГ-ын Хяналт шалгалт үнэлгээ дотоод аудитын газар нь тухайн онд Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу шаардлагатай тохиолдолд санхүүгийн аудитыг гүйцэтгэдэг ба тайлант онд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад санхүүгийн аудит хийлгэх чиглэл өгөгдөөгүй тул аудит хийгдээгүй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн ба 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцож, 1,583.8 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 1, эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд захирагч 9, ТӨҮГ 5, төсөл 1, Засгийн газрын тусгай сан 1, нийт 17 байгууллага аудитад хамрагдсан байна.

Хүснэгт 1 (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр, тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	5		
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	5			
3	Төсөл		1		
4	Засгийн газрын тусгай сан	1			
5	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
	Дүн	11	6		

Эх сурвалж: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн шууд захирагч 2, Засгийн газрын тусгай санд төрийн аудит, төсвийн шууд захирагч 2, ТӨҮГ 5 байгууллагад хараат бус аудитын компаниуд



гэрээгээр аудитыг тус тус гүйцэтгэн бүх байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 12,027.5 сая төгрөгийн 41 алдаа, зөрчил илрүүлснээс 74.2 хувь буюу 8,918.6 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 9.7 хувь буюу 1,171.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5.5 хувь буюу 666.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага өгч, 10.6 хувь буюу 1,270.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг хүргүүллээ.

2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 (Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт, сая төгрөгөөр)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн шууд захирагч	17	2,186.3	1	1,171.3	4	501.0	12	514.0
2	Төрийн өмчит үйлдвэрийн газар	16	859.5	1	0.5	2	165.6	13	693.4
3	Засгийн газрын тусгай сан	2	63.1	-	-	-	-	2	63.1
Дүн		35	3,108.9	2	1,171.8	6	666.6	27	1,270.5

Эх сурвалж: 2018 оны Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг тоймлон харуулбал:

1. Төсвийн шууд захирагчийн байгууллагуудад нийт 2,186,3 сая төгрөгийн 17 алдаа зөрчил илэрснээс залруулагдаагүй 1,171.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 501.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 514.0 сая төгрөгийн алдааг засах 12 зөвлөмж;
2. Төрийн өмчит үйлдвэрийн газруудад нийт 9,778.1 сая төгрөгийн 22 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 8,918.6 сая төгрөгийн 6 алдааг залруулж, залруулагдаагүй 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 165.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 693.4 сая төгрөгийн алдааг засах 13 зөвлөмж;
3. Засгийн газрын тусгай санд нийт 63.1 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс алдааг засах 2 зөвлөмж өгсөн.

2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцохоор шийдвэрлэлээ.



Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгасан ба бусад хэлбэрээр шийдвэрлэсэн аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Худалдан авах ажиллагааны талаар

Үндэсний Брэндийн бодлогын зөвлөлийн Ажлын алба нь нэр бүхий 8 аж ахуйн нэгжтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд заасан хугацаа дуусаагүй, ажил бүрэн гүйцэтгээгүй байхад ажил хүлээлцсэн актаар гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн гэж дүгнэж, баталгаажуулан нийт 449.7 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдэл: Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг аж ахуйн нэгж бүрээр дахин хянаж, үнэлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндэсний Брэндийн бодлогын зөвлөлийн ажлын албаны “Монгол Улсын үндэсний уламжлал, үнэт зүйл, ялгарах онцлог чанар болон хөгжлийн бодлого, үйл ажиллагааг гадаад дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх”-ээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нийт 203,278.4 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсанаас бараа, ажил үйлчилгээний зардалд 87,100.4 сая, урсгал шилжүүлэгт 1,388.9 сая, татаасд 8,275.2 сая, хөрөнгийн зардалд 89,518.7 сая, нийт 186,283.2 сая төгрөгийг зарцуулж, 16,995.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь тайлант онд Эдийн засгийн бодлогын зөвлөлийн Ажлын албаны төлөвлөсөн судалгааны ажил хийгдээгүй, “Үндэсний Дата төв” УТҮГ-ын “Дархан дахь нөөц төв” ашиглалтад ороогүй, 2018 онд эргэн төлөгдөх концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдлийг гүйцэтгэлээр олгохоор хойшлуулсан, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн Ажлын албаны төсөл сонгон шалгаруулалтын үр дүнд төслийн төсөвт өртөг буурсан зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.



“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитаар тус байгууллагад хуулийн хэрэгжилт “хангалттай” гэж үнэлсэн ба 799,791.9 сая төгрөгийн 2212 мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,387.7 сая төгрөгийн 40 алдаа, зөрчил илэрч, залруулагдаагүй 107.6 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт, 26.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 5,253.4 сая төгрөгийн алдааг залруулах 27 зөвлөмж өгсөн ба төлбөрийн акт болон албан шаардлагыг 100 хувь биелүүлж, зөвлөмжийн биелэлт 99.8 хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын хэмжээг зохицуулахтай холбоотой эрх зүйн асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Үндэсний Брэндийн бодлогын зөвлөлийн ажлын алба нь сурталчилгаа хийх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээхэд гарах зардлын хэмжээг зохицуулсан журам байхгүй, гарсан зардлыг тухайн үйл ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээгээр олгож байна.

3.1.2 Эрсдэл:

Сурталчилгаа хийх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээхэд гарах зардлын хэмжээг нарийвчлан тогтоогоогүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, журамд нийцүүлэн судалгаанд үндэслэн сурталчилгаа хийх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээхэд гарах зардлын хэмжээг нарийвчлан тогтоох талаар санал боловсруулж, асуудлыг шийдвэрлүүлэх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлыг хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан.

3.2 Авлагатай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч тайлант онд 11.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба өмнөх оны авлагыг барагдуулаагүй байхад “Цацрагийн үүсгүүр түр хадгалалтын гэрээ”-г дахин сунгаж 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт авлагын үлдэгдэл 34.8 сая төгрөгт хүрсэн байна.

3.2.2 Эрсдэл:



Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй, найдваргүй авлага үүсэх, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого буурах эрсдэлтэй.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлыг хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	159,866,918.5	166,054,762.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,614,480.4	47,144,797.4
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	5,831,510.3
АВЛАГА	25,840,572.0	12,157,481.2
УРЬДЧИЛГАА	8,071,370.0	9,846,197.7
БАРАА МАТЕРИАЛ	88,336,130.8	91,074,776.3
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	4,365.2	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	437,991,679.8	691,394,186.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	437,991,679.8	691,394,186.5
Биет хөрөнгө	423,592,322.0	551,243,105.3
Биет бус хөрөнгө	9,139,676.5	134,874,524.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,259,681.3	5,276,556.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	597,858,598.3	857,448,949.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	66,585,557.2	70,311,227.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,500,381.1	17,963,890.4
Өглөг	14,981,876.5	15,260,170.3
Урьдчилж орсон орлого	1,518,504.6	2,703,720.1
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,085,176.2	52,347,337.5
Урт хугацаат зээл	50,085,176.2	52,347,337.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	531,273,041.1	787,137,721.5
Засгийн газрын хувь оролцоо	531,273,041.1	787,137,721.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	63,527,455.3	141,415,250.3
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	138,573,124.9	141,058,709.2
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	-	137,098.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,463,938.5	50,236,843.7
Хуримтлагдсан үр дүн	320,015,580.0	412,109,775.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,692,942.3	42,180,043.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	597,858,598.3	857,448,949.4



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	377,210,228.9	278,533,962.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,746,107.0	93,709,701.9
Нийтлэг татварын бус орлого	90,656,451.2	92,987,569.4
Хөрөнгийн орлого	17,079,820.6	708,904.5
Тусламжийн орлого	9,835.2	13,228.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,464,121.9	184,824,260.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	178,216,611.4	182,455,400.0
УРСГАЛ ЗАРДАЛ	174,006,580.7	182,428,400.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,134,975.2	127,369,735.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,547,742.9	46,765,856.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,381,225.5	2,191,250.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,660,983.5	1,644,752.7
Хангамж, бараа материалын зардал	4,689,609.6	1,064,798.5
Нормативт зардал	8,372.0	32,578.6
Эд хогшил, урсгал засварын зардал	1,194,909.5	921,389.7
Томилолт, зочны зардал	928,021.7	669,181.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,091,930.8	17,932,972.2
Бараа үйлчилгээний бусад зардал	56,632,179.8	56,146,955.2
ТАТААС	-	1,590,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,871,605.5	53,468,664.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,210,030.7	27,000.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	198,993,617.5	96,078,562.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	- 1,009,544.8	144,971.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,263,923.9	20,338,581.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	191,720,148.8	75,884,953.2



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	383,884,643.2	338,116,364.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,425,718.3	152,228,103.7
Нийтлэг татварын бус орлого	97,336,062.4	151,519,199.2
Хөрөнгийн орлого	17,079,820.6	708,904.5
Тусламжийн орлого	9,835.2	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,458,924.9	185,888,261.1
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	161,304,204.2	204,918,202.2
УРСГАЛ ЗАРДАЛ	161,304,204.2	204,918,202.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,359,603.7	146,301,382.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,216,413.5	63,504,873.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,820,724.2	6,858,271.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,296,962.7	17,921,670.8
Хангамж, бараа материалын зардал	3,059,168.8	5,762,190.0
Нормативт зардал	10,450.2	47,414.9
Эд хогшил, урсгал засварын зардал	616,346.4	1,656,151.2
Томилолт, зочны зардал	486,020.8	685,653.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,969,040.3	20,320,063.5
Бараа үйлчилгээний бусад зардал	20,884,476.7	29,545,093.8
ТАТААС	3,643,017.6	4,187,820.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,301,582.9	54,428,999.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	222,580,439.0	133,198,162.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	74,012.2	878,954.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	206,447,584.3	123,476,629.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	206,447,584.3	123,476,629.8
Дотоод эх үүсвэрээр	206,447,584.3	123,476,629.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-206,373,572.1	- 122,597,675.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	- 2,880,342.6	- 1,070,170.7
Бусад эх үүсвэр	22,581.9	1,301,373.1
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,902,924.5	2,371,543.8
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	13,326,524.2	9,530,316.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,287,956.2	37,614,480.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,614,480.4	47,144,797.3



4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,392,334.1		327,392,334.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 2,616,405.3		- 2,616,405.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,775,928.8		324,775,928.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	- 1,194,754.0		- 1,194,754.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	16,728,108.8		16,728,108.8
Зарласан ногдол ашиг	- 756,391.3		- 756,391.3
Тайлант үеийн үр дүн	191,720,148.7		191,720,148.7
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,273,041.0		531,273,041.0
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	531,273,041.0		531,273,041.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,977,012.2		19,977,012.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	551,250,053.2		551,250,053.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	33,638,738.2		33,638,738.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	9,219,456.8		9,219,456.8
Өмчид гарсан өөрчлөлт	117,359,220.3		117,359,220.3
Зарласан ногдол ашиг	- 214,700.1		- 214,700.1
Тайлант үеийн үр дүн	75,884,953.2		75,884,953.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	787,137,721.5		787,137,721.5



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,982.8		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,278,394.0	186,283,201.6	-16,995,192.4	91.6
УРСГАЛ ЗАРДАЛ	98,058,571.9	96,764,541.3	-1,294,030.6	98.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,302,031.1	87,100,444.1	-1,201,587.0	98.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,187,397.9	41,952,027.9	-235,370.0	99.4
Үндсэн цалин	41,872,406.3	41,780,290.8	-92,115.5	99.8
Гэрээт ажлын хөлс	314,991.6	171,737.1	-143,254.5	54.5
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,632,754.6	1,603,170.7	-29,583.9	98.2
Тэтгэврийн даатгал	596,372.0	1,501,615.9	905,243.9	251.8
Тэтгэмжийн даатгал	72,222.8	25,604.8	-46,618.0	35.5
ҮОМШӨ-ний даатгал	61,465.5	18,535.0	-42,930.5	30.2
Ажилгүйдлийн даатгал	14,707.8	8,860.0	-5,847.8	60.2
Эрүүл мэндийн даатгал	887,986.5	48,555.0	-839,431.5	5.5
Бараа үйлчилгээний урсгал зардал	44,481,878.6	43,545,245.5	-936,633.1	97.9
Гэрэл, цахилгаан зардал	487,970.1	359,491.4	-128,478.7	73.7
Түлш, халаалтын зардал	157,146.1	104,557.9	-52,588.2	66.5
Цэвэр, бохир усны зардал	37,227.3	36,980.2	-247.1	99.3
Бичиг хэргийн зардал	199,031.3	196,741.8	-2,289.5	98.8
Тээвэр, шатахууны зардал	121,803.6	122,612.0	808.4	100.7
Шуудан, холбооны зардал	160,364.7	126,824.7	-33,540.0	79.1
Дотоод томилолтын зардал	162,958.1	131,978.7	-30,979.4	81.0
Гадаад томилолтын зардал	171,117.7	166,659.1	-4,458.6	97.4
Ном, хэвлэлийн зардал	26,423.5	26,458.1	34.6	100.1
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	78,119.6	73,747.7	-4,371.9	94.4
Жижиг эд хогшил худалдан авах зардал	345,739.1	372,729.0	26,989.9	107.8
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	22,657.6	22,720.2	62.6	100.3
Төлбөр, хураамж, жижиг татварууд	269,376.6	236,369.0	-33,007.6	87.7
Банкны үйлчилгээний хураамж	6,951.5	6,694.2	-257.3	96.3
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,071,115.2	5,834,979.8	-236,135.4	96.1
Маягт хэвлүүлэх зардал	263,947.4	226,190.2	-37,757.2	85.7
Урсгал засварын зардал	664,758.6	658,910.1	-5,848.5	99.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	24,734.9	36,661.9	11,927.0	148.2
Бусад зардал	33,640,195.9	33,258,485.1	-381,710.8	98.9
Байрны түрээсийн зардал	125,590.6	102,995.5	-22,595.1	82.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,444,649.2	1,442,458.9	-2,190.3	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,389,085.6	1,388,880.7	-204.9	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,354,520.2	1,354,516.3	-3.9	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,565.4	34,364.5	-200.9	99.4
ТАТААС	8,367,455.2	8,275,216.5	-92,238.7	98.9



Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952.0	4,429,952.0	0.0	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,937,503.2	3,845,264.5	-92,238.7	97.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,219,822.1	89,518,660.3	-15,701,161.8	85.1
Дотоод хөрөнгө оруулалт	105,219,822.1	89,518,660.3	-15,701,161.8	85.1
Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	94,158,410.7	89,221,409.8	-4,937,000.9	94.8
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж	11,061,411.4	297,250.5	-10,764,160.9	2.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	203,278,394.0	186,275,180.7	-17,003,213.3	91.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,013,818.8	2,188,552.1	174,733.3	108.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,462,949.0	1,476,531.6	13,582.6	100.9
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,761,411.4	0.0	-10,761,411.4	0.0
Улсын төсвөөс санхүүжих	189,040,214.8	182,610,097.0	-6,430,117.8	96.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,961.9		
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		0.0		
Байгууллагын тоо	7	7		
Ажиллагсад бүгд	399	399		
Удирдах ажилтан	14	14		
Гүйцэтгэх ажилтан	341	341		
Үйлчлэх ажилтан	22	22		
Гэрээт ажилтан	22	22		



5 Хавсралт

5.1 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/3/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд		Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
Төсвийн шууд захирагч					
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар					
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 322 дугаар тогтоолын дагуу Монголросцветмет ХХК улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашиг 1,171,317.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн,	1,171.3	Төлбөрийн акт тогтоосон	Монголросцветмет ХХК-ийн гүйцэтгэх захирал	Б.Мөнхбат
2	<ul style="list-style-type: none"> Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гурвалсан гэрээний дагуу байршуулсан 535 түрээслэгчийн 988.1 сая төгрөгийн түрээсийн барьцааны үлдэгдэлтэйгээс 2018.12.31-ны байдлаар 107 түрээслэгчийн 322.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын байршуулсан нийт 988.1 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг Төрийн сан дахь тус байгууллагын "түр" дансанд байршуулсан байна. 	322.3	Зөвлөмж өгсөн	ТӨБЗГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Ганбат Ж.Мөнхтүвшин
	Дүн	1,493.6			



Үндэсний хөгжлийн газар					
3	<ul style="list-style-type: none"> Хадатын хүрээ ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдөр ҮХГ/079 дугаартай "Байгууллагын чиг үүргийн шинжилгээ, давхардал хийдлийг арилгах судалгааны ажлыг гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулж 9.3 сая төгрөгийн төлбөртэй гүйцэтгүүлсэн, Жи Эс Эй Эс ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдөр ҮХГ/080 дугаартай "Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төслүүдийн бүртгэл хөтлөх, тэдгээрийн явц болон хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж ажлын үр дүнг харгалзахгүйгээр 8.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, Тайлант онд гадаад албан томилолтоор ажиллахдаа бизнес ангиллын нислэгээр зорчиж илүү төлсөн 6.5 сая, томилолтын хугацааг хэтрүүлэн ажилласан хугацаанд тооцож олгосон 5.1 сая, нийт 11.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 	29.9	Албан шаардлага өгсөн	ҮХГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Баярсайхан М.Бямбахишиг
4	<ul style="list-style-type: none"> Удам соел ХХК-тай 2018.12.26-ны өдөр байгуулсан "Судалгаа, шинжилгээний ажлын болон үйл ажиллагааны тайлангийн эмхэтгэл хэвлүүлэх" ажлын гэрээнд гүйцэтгэх хугацаа заагаагүй, мөн төлбөрийг 100 хувь буюу 9.4 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн, алданги тооцоогүй, ажил гүйцэтгэж дуусаагүй тул авлага үүссэн, Барьцааны дансанд 2017 оны концессын эргэн төлөлтийн үлдэгдэл 4,786.3 сая төгрөгийг байршуулсан ба хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлээгүй, Бараа үйлчилгээний бусад зардлаас гадаад арга хэмжээний хүлээн авалтын зардалд 17.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 	26.8	Зөвлөмж өгсөн	ҮХГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Баярсайхан М.Бямбахишиг
Дүн		56.7			
Үндэсний Брэндийн зөвлөлийн Ажлын алба					



Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Нэр бүхий 8 аж ахуйн нэгжтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд заасан хугацаа дуусаагүй, ажил бүрэн гүйцэтгээгүй байхад ажил хүлээлцсэн актаар гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн гэж дүгнэж, баталгаажуулан нийт 449.7 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг бүрэн олгосон,.	449.7	Албан шаардлага өгсөн	ҮББЗАА-ны дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхбат Т.Найдан
6	Сурталчилгаа хийх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээхэд гарах зардлын хэмжээг зохицуулсан журам байхгүй, гарсан зардлыг тухайн үйл ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээгээр олгож байна.	-	Зөвлөмж өгсөн	ҮББЗАА-ны дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Мөнхбат Т.Найдан
Дүн		449.7			
Цөмийн энергийн комиссын Ажлын алба					
7	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч тайлант онд 11.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба өмнөх оны авлагыг барагдуулаагүй байхад үүсгүүр хадгалах гэрээг дахин сунгасан байна. Мөн 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт авлагын үлдэгдэл 34.8 сая төгрөгт хүрсэн байна.	34.8	Зөвлөмж өгсөн	ЦЭКАА-ны дарга, Ахлах нягтлан бодогч	Г.Манлайжав Б.Долзодмаа
Дүн		34.8			
МОНЦАМЭ агентлаг					
8	Тайлант оны 2,3,7 дугаар саруудын цалинг илүү тооцож олгосноос шалтгаалж 33 ажилтанд авлага өглөгийн тооцоо үүсгэсэн, мөн 1 ажилтанд 9 хоногийн цалин илүү тооцож олгосон,	1.6	Албан шаардлага өгсөн	МОНЦАМЭ агентлагийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
9	<ul style="list-style-type: none"> • Тоног төхөөрөмжийн болон сайтын сайжруулалтыг 1 тендерээр зарлаж гүйцэтгэлийг хүлээн авсан, • Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдлийг биет байдлаар тулган тоолж үзэхэд “Номын фонд” гэсэн нэртэйгээр бөөн дүнгээр бүртгэсэн байна 	81.6	Зөвлөмж өгсөн	МОНЦАМЭ агентлагийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
Дүн		83.2			
Харилцаа холбооны зохицуулах хороо					



Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Сахилгын шийтгэл буруу ногдуулж, ажилтныг ажлаас халсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны 19.6 сая төгрөгийн нөхөн олговор, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж байгууллагад хохирол учруулсан,	19.6	Албан шаардлага өгсөн	ХХЗХ-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
11	<ul style="list-style-type: none"> Тайлант онд авлага 234.2 сая төгрөгөөр буурсан хэдий ч 2-6 жилийн насжилттай 2,704.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, Харилцаа холбооны зохицуулах хорооны ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ажлын үр дүнгээр урамшуулал олгох журам нь Засгийн газрын тогтоол, Хөдөлмөрийн дотоод журамтай нийцэхгүй байна. 	48.7	Зөвлөмж өгсөн	ХХЗХ-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Чинзориг Н.Халиунаа
Дүн		68.3			
Төрийн өмчит үйлдвэрийн газар					
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК					
1	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн 431.6 мянга, дутагдсан хөрөнгийн төлбөр 104.5 мянга, нийт 536.1 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх,	0.5	Төлбөрийн акт тогтоосон	МХС ХХК-ийн захирал, Нягтлан бодогч	Ч.Золбаяр, М.Баярсайхан
2	<ul style="list-style-type: none"> Ихэр түрүү ХХК-тай байгуулсан 77,741.4 мянга, Мэгүүн медиа ХХК-тай байгуулсан 32,360.0 мянга, нийт 110,101.4 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулахдаа харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулаагүй, Арбэл Алтай ХХК, Хатанбаатар ХХК-иудтай нийт 21,698.4 мянган төгрөгийн зураг төсвийн гэрээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалт явуулаагүй байна. 	11.8	Албан шаардлага	МХС ХХК-ийн захирал, Нягтлан бодогч	Ч.Золбаяр, М.Баярсайхан
3	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Архангай болон Хөвсгөл аймгуудын салбарт: - Хөрөнгө данснаас хасах, актлахтай холбоотой баримтжуулалт хийгдээгүй 12,880.0 мянган төгрөгийн зөрчил, - Анхан шатны баримтжуулалтад гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж 	72.6	Зөвлөмж өгсөн	МХС ХХК-ийн захирал, Нягтлан бодогч	Ч.Золбаяр, М.Баярсайхан



	<p>баталгаажуулаагүй болон НБББББ-ийг баримтлаагүй 8,030.0 мянган төгрөгийн зөрчлүүд,</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн байдлаар урьдчилж төлсөн тооцоо дансанд Хас кабель ХХК-д хамаарах 16,345.9 мянган төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо 2009 оноос үүссэн байна. 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар уг хөрөнгийг ашиглаж байгаа хэдий ч урьдчилж төлсөн тооцоо данснаас үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгээгүй, • Бараа материалын дансанд 2014 оноос өмнө худалдан авсан 27,082.8 мянга, 2015 онд худалдан авсан 4,442.5 мянган төгрөгийн насжилт өндөртэй бараа материал байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны онцлогоос хамаарч зайлшгүй байлгах бараа материалын нөөцийг хэмжээ тогтоосон зохицуулалт НБББББ-т тусгагдаагүй, • Хотын болон аймгийн салбаруудад 3,779.2 мянган төгрөгийн тайлант онд ногдох урьдчилж төлсөн зардлыг буруу тооцоолж бүртгэсэн байна. 				
	Дүн	204.9			
Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ					
4	<ul style="list-style-type: none"> • Тус байгууллагын захирлын тушаалаар Ш.Батдэлгэр 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 5,000.0 мянган төгрөг олгосон, • Тайлант онд 16,175.0 мянган төгрөгийн компьютер, Буянт оюу ХХК-иас 12,589.6 мянган төгрөг үйлчилгээ, нийт 28,764.6 мянган төгрөгийг харьцуулалтын үнийн арга хэрэглэлгүй шууд худалдан авсан, 	33.8	Албан шаардлага өгсөн	Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын дарга, Нягтлан бодогч	С.Цагаанхүү, Б.Батмөнх
5	“Мэдээлэлжсэн ухаалаг нийгэм” ТББ-д 6.0 сая төгрөгийн сургалт, арга хэмжээний төлбөр төлсөн боловч ажил үйлчилгээ худалдан авсан баримтгүй,	6.0	Зөвлөмж өгсөн		
	Дүн	39.8			
Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ					



6	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн програм хангамж нь алдаатай ажилладаг, санхүүгийн тайлан мэдээг бүрэн бэлтгэн гаргадаггүй. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ нь түрээслэгч Оюуны өмч улсын бүртгэлийн газартай 1м2-ыг 7,772.5 төгрөгөөр түрээсийн гэрээ байгуулсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119-р тогтоолын хавсралтад заасан түрээсийн төлбөрийн 1м2-ын жишиг үнэтэй нийцэхгүй байна. 	12.0	Зөвлөмж өгсөн	Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирал, нягтлан бодогч	Ц.Содномдамба Д.Цэрэндолгор
Дүн		12.0			
Үндэсний “Дата төв” УТҮГ					
7	<ul style="list-style-type: none"> ТҮЦ машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн үнэ, бэлэн мөнгө уншигчийн машины үнэ зэрэг худалдан авалтанд тендер зарлаагүй. Урсгал засварын ажлуудад тендер зарлаагүй. Гэрээт ажиллагсад олгосон цалинг цалингийн зардалд бүртгэсэн боловч НДШ суутгаагүй, ХХОАТ тооцож төлсөн, Бараа материалын дансанд 41,894.8 мянган төгрөгийн ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс бүртгэгдсэн, НББ-ийн бодлогын баримт бичигт шинэчлэлт, сайжруулалт хийгдээгүй байна. 	415.2	Зөвлөмж өгсөн	Үндэсний “Дата төв” УТҮГ-ын захирал	Б.Батжаргал
Дүн		415.2			
Монголын цахилгаан холбоо ХК					
8	<ul style="list-style-type: none"> Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд компани үүсгэн байгуулагдсан 1995 оноос хойш 24 жилийн хугацаанд дахин үнэлгээг огт хийж байгаагүй, 2018 оны санхүүгийн тайланд тэдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь илэрхийлээгүй, Улсын хэмжээнд 2014-2015 онд Засгийн газрын оролцоотойгоор хэрэгжүүлсэн 150 сумыг шилэн кабелиар холбох төслийн ажилтай холбоотой гэрээ хэлцэл, акт зэрэг 	187.6	Зөвлөмж өгсөн	Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирал	М.Алтаночир



Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	баримт байхгүйгээс түүнтэй холбоотойгоор өмнөх онуудад алдаатай хүлээн зөвшөөрч бүртгэгдсэн /5 аймгийн 19 сум/ 253.7 сая төгрөгийн авлага, 66.1 сая төгрөгийн өр төлбөрийн алдааг залруулж чадаагүй байна.				
	Дүн	187.6			
Засгийн газрын тусгай сан					
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан					
9	<ul style="list-style-type: none"> Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 520 байгууллагаас улсын төсөвт 3,000,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,936,893.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 63,106.3 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар дутуу төвлөрүүлсэн, Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд нь албан татвар ногдуулах орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийн тайлангаа дараа оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлж, төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцуулдаг боловч тус сан нь тайлант оны 3-р улирлын санхүүгийн тайланг үндэслэн тооцоолж авлага үүсгэн бүртгэсэн байна. 	63.1	Зөвлөмж өгсөн	ХХМТГ-ын дарга, Нягтлан бодогч	Б.Чинбат Т.Халиунаа
	Дүн	63.1			
	Нийт дүн	3,108.9			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 дугаар сарын 22

№ 02/222

Улаанбаатар хот

САГ-2019/3/СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын түүвэрт хамрагдсан Үндэсний Брэндийн бодлогын зөвлөлийн Ажлын албанд дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

- Нэр бүхий 8 аж ахуйн нэгжтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд заасан хугацаа дуусаагүй, ажил бүрэн гүйцэтгээгүй байхад ажил хүлээлцсэн актаар гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн гэж дүгнэн баталгаажуулж нийт 449.7 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг аж ахуйн нэгж бүрээр дахин хянаж үнэлэх, төсөл хөтөлбөрийг яаралтай хэрэгжүүлж дуусгах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч, биелэлтийг 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний Брэндийн бодлогын зөвлөлийн ажлын албаны дарга Н.Дэмбэрэл, ахлах нягтлан бодогч Т.Найдан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]* О.БАЯРМАА

ЗӨВШӨӨРСӨН:
ҮНДЭСНИЙ БРЭНДИЙН БОДЛОГЫН
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА *[Signature]* Н.ДЭМБЭРЭЛ
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ *[Signature]* Т.НАЙДАН

Акт, албан шаардлагын биелэлт хянагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцаагаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.